

Төсөл  
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн  
сайдын 2021 оны ... дугаар сарын ...-ны  
өдрийн ..... дугаар тушаалын хавсралт

## МОНГОЛ УЛСАД ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН УРГАМЛЫН ГЕНЕТИК НӨӨЦТЭЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол улсад хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөц (ХХААУГН)-ийг бүртгэх, мэдээллийн систем хөтлөх, генетик нөөцийг амьдаар хадгалж хамгаалах, судлах, цуглуулж, баяжуулах, хуваарилахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Монгол улсын хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцтэй холбоотой үйл ажиллагаанд Таримал ургамлын үр сортын тухай Монгол улсын хууль, Монгол улсын олон улсын гэрээ “Хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн Олон улсын гэрээ”, Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ)-ын дэргэдэх Хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн комиссын (ХХААУГНК)-оос баталгаажуулсан стандарт болон бусад холбогдох стандарт, аргачлалууд, энэхүү журам болон монгол улсын бусад эрх зүйн актуудыг мөрдөнө.

1.3 Энэхүү журам нь Монгол улсад хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг бүртгэх, мэдээллийн систем хөтлөх, генетик нөөцийг амьдаар хадгалж хамгаалах, судлах, цуглуулж байжуулах, хуваарилах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэдэд хамаарна.

### Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1 “Хүнс, Хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөц” (ХХААУГН) гэж хүнс ба хөдөө аж ахуйн салбарт бодитой болон боломжит хувь нэмэр оруулах үнэ цэнэ бүхий ургамлын гаралтай генетик материалыг,

2.2 “Ургамлын генетик материал” гэж удамшлын идэвхитэй хэсгийг агуулсан үржлийн болон вегетатив эрхтэн зэрэг ургамлын гаралтай материалыг,

2.3 “Генбанк” гэж генетик материалыг амьдаар *ex situ* нөхцөлд хадгалах зориулалттай чийг, температур бусад хадгалалтын нөхцлийг стандартын дагуу бүрдүүлсэн байгууламж,,

2.4 “*In-situ* хадгалах” гэж биологийн төрөл зүйлийн бүрэлдэхүүн хэсгийг түүний амьдардаг уугуул нутаг экосистем, байгалийн орчинд нь нөхөн сэргээж цогцоор нь хадгалж хамгаалах, харин тэжээвэр болон таримал зүйлийн хувьд түүнийг өвөрмөц шинж чанараа олж авсан тэр нутаг оронд хадгалах,

2.5 “*Ex-situ* хадгалах” гэж биологийн төрөл зүйлийн бүрэлдэхүүн хэсгийг түүний амьдардаг уугуул нутаг орны гадна хадгалах,

2.6 Үндсэн цуглуулга гэж генетик нөөцийн үнэ цэнэ, үндсэн шинж чанарыг алдагдуулахгүйгээр урт удаан хугацаанд хадгалах зориулалттай ургамлын генетик материалын цуглуулга,

2.7 Ажлын цуглуулга гэж судалгаанд зориулж хуваарилах боломжтой генетик материалын цуглуулга,

2.8 Цөм цуглуулга гэж ургамлын генетикийн олон янз байдлын цар хүрээг хамгийн сайн төлөөлж чадах хязгаарлагдмал тооны генетик материалын цуглуулга.

2.9 Аюулгүй нөөц цуглуулга гэж байгалийн болон бусад аюул, гамшигт үзэгдэл, хохирлын үед генетик нөөц устхаа хамгаалах зорилгоор газар зүйн өөр бүс нутагт байрлуулсан, үндсэн цуглуулын хуулбар,

2.10 Дээж гэж ургамлын генетик материал тус бүрийг төлөөлөх бага хэмжээтэй хэсэг,

- 2.11 “Сорт” гэж тогтвортой онцлог шинж, тэмдгүүдээр бусдаас ялгаатай, ботаникийн нэг бүлгэмдлийн доторх ургамлын бүлгийг;
- 2.12 In vitro хадгалах – ургамлын эдийн өсгөврийг хадгалах
- 2.13 ДНХ гэж Дезоксирибо нуклейн хүчил
- 2.14 ОУҮСХ - Олон Улсын Үр Судлалын Холбоо
- 2.15 УГНОУТ Ургамлын Генетик Нөөцийн Олон Улсын Төв
- 2.16 БОЯБТ- Биологийн олон янз байдлын олон улсын төв
- 2.17 СМДГ- Стандарт Материал Дамжуулах гэрээ
- 2.18 Дескриптор - Ургамлын дескриптор– ургамлыг таньж тодорхойлох, үнэлэх шалгуур үзүүлэлтүүд
- 2.19 ХХААУГНОУГ-Хүнс Хөдөө Аж Ахуйн Ургамлын Генетик Нөөцийн Олон Улсын Гэрээ
- 2.20 НҮБ-ын ХХААБ- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага
- 2.21 МХЕГ-Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар
- 2.22 ОТТ - Олон Талт Тогтолцоо
- 2.23 ДОТ - Дижитал объект тодорхойлогч
- 2.24 ДДМС - Даян дэлхийн мэдээллийн систем

Гурав. Хүнс, хөдөө аж ахуйн таримал ургамлын генетик нөөцийн бүртгэл, мэдээллийн үндэсний сан

3.1 Монгол улсад хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн бүртгэл, мэдээллийн үндэсний санг хөтлөх ажлыг энэ журмын 8.2-т заасан ургамал, газар тариалангийн туршилт, судалгааны ажил гүйцэтгэдэг төрийн үйлчилгээний эрдэм шинжилгээ хүрээлэнгийн дэргэдэх Генбанк гүйцэтгэнэ.

3.2 Генбанкид хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн бүртгэл мэдээллийн үндэсний санг хөтлөн явуулах ажлыг зохион байгуулах чиг үүрэгтэй орон тооны нэгж,, бүртгэлийн ажилтан ажиллана. Түүний үйл ажиллагаанд Генбанкийн менежерээр дамжуулан хүрээлэнгийн удирдлага хяналт тавьж газар тариалан эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

3.3 Генбанкийн бүртгэл, мэдээллийн үндэсний сан нь өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон цахим программ хангамжийг ашиглана. Генетик материалын бүртгэл мэдээллийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хадгална.

3.4 Генбанкийн бүртгэл мэдээллийн үндэсний сан нь генбанкийн стандартын дагуу бүрдүүлсэн, ургамлын генетик материалыг бүртгэх, хадгалах, хадгалалтын явцыг хянах, генетик материалыг сэргээн үржүүлэх, судалж үнэлэх, хуваарилахтай холбоотой тоо, мэдээлэл агуулсан бүрэлдэхүүн хэсгүүдтэй байна. Үүнд: .

1. Генетик нөөцийн паспортын бүртгэл
2. Генбанкийн менежментийн бүртгэл
3. Генетик нөөцийн судалгаа, үнэлгээний мэдээллийн бүртгэл
4. Бусад бүртгэл

3.5. Бүртгэл мэдээллийн сан нь хадгалж байгаа генетик материалын бүртгэлийн дугаар, ургамлын ба сортын нэр, гарал үүсэл, ургамлын морфологи, биологи, аж ахуйн, тэсвэрийн зэрэг олон шинж тэмдгүүдээр хайлт хийх, ангилан ялгах, тайлагнах, цахим сүлжээнд ажиллах боломжтой үйлдлийн системтэй байна.

3.6 Бүртгэл, мэдээллийн үндэсний сан нь хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг бүртгэх, мэдээллийн систем хөтлөх, генетик нөөцийг амьдаар хадгалж хамгаалах, сэргээн үржүүлэх, судлах, хуваарилах чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургууль бусад төрийн байгууллагуудыг багтаасан нэгдсэн сүлжээ байна.

3.7 Хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн бүртгэл, мэдээллийн үндэсний сангийн мэдээг энэ журмын 3.1 заасан хуулийн этгээд жил бүрийн 12 сард багтааж Хүнс

хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Үндэсний статистикийн хороонд хүргүүлнэ

### 3.8 Хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн паспортын бүртгэл

3.8.1 Генбанкид хадгалж байгаа генетикийн материал тус бүр паспортын бүртгэлтэй байх бөгөөд НҮБ-ын ХХААБ-аас боловсруулж олон улсын хэмжээнд ашиглаж байгаа паспортын бүртгэлийн загвараар мэдээллийг бүрдүүлнэ. /Хавсралт 1/

3.8.2 Бүх ургамлын генетик материалын паспортын бүртгэл нэг ижил бүтэцтэй байна.

3.8.3 Тухайн генетик материалын зураг, гарал үүслийн байршлын солбицлын мэдээлэл, кино бичлэг гэх мэт мэдээллийн бусад материалыг бүртгэлд хавсаргана.

### 3.9 Хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг Генбанкид шинээр бүртгэх

3.9.1 Ургамлын генетикийн шинэ материалыг түүний дагалдах бичиг баримт, нэрсийн жагсаалттай тулгаж шалгах бөгөөд хэрэв дагалдах баримт бичиг байхгүй эсвэл мэдээлэл зөрж байвал нэмэлт жагсаалт тусад нь гаргана.

3.9.2 Ургамлын генетик материал тус бүрийг дагалдаж ирсэн, ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн гэрчилгээнд тулгуурлан хортонд идэгдсэн, мөөгөнцөрөөр өвчилсөн, гэмтсэн, хагарсан, хоосон юмуу хорчийсон, хог ургамлын хольцтой эсэх гэх мэт төлөв байдлыг шалгана. Хэрэв, ургамлын эрүүл байдал хорио цээрийн бичиггүй, эсвэл эрүүл ахуйн хувьд эргэлзээтэй материалыг тусгаарлаж Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газартай (МХЕГ) хамтарч устгах эсвэл халдваргүйжүүлж хорио цээрийн тусгаарлагдсан лаборатори, хүлэмж, талбарт тарьж судлана. Энэ тухай нийлүүлэгч талд мэдэгдэж, шаардлагатай тохиолдолд эрүүл цэвэр үр, ургамлын материал захиалж авна.

3.9.3 Дагалдах баримт бичиг болон генбанкийн паспортын бүртгэлийн мэдээлэлд тулгуурлан тухайн генетик материал нь генбанкид өмнө нь бүртгэлтэй байсан эсэх, өөр эх үүсвэрээс ирсэн эсэхийг нягталж шалгана.

3.9.4 Эрүүл ахуй, хорио цээрийн хяналтанд тэнцсэн генетик материалын дээжийг генбанкд хадгалах эсэхийг дараах үзүүлэлтүүдийг үндэслэн шийдвэрлэнэ. Үүнд:

- генетик материал нь хамгийн сайн чанартай байх
- Генетик материалын тоо хэмжээ нь хангалттай буюу 2-3 удаа сэргээн шинэчлэхэд хүрэлцэхүйц хэмжээтэй байх,
- Соёололтын хувь таримал зүйлүүдэд 85%-аас дээш, байгалийн зэрлэг зүйлүүдэд 75%-ээс дээш байх,

3.9.5 Генетик материалын төлөв байдал, сайн байгаад эдгээр дээжүүд өмнө бүртгэгдээгүй бол тус бүрд түр “И” буюу интродукцийн дугаар өгч мэдээллийг шинээр ирсэн дээжийн түр бүртгэлд бүртгэнэ

3.9.6 Интродукцийн дугаар өгч шинээр бүртгэсэн материалыг үржүүлж олшруулсны дараа болон анхан шатны үнэлгээ хийсэн судалгааны дүнг үндэслэн Монгол каталогийн /МК дугаар/ үндсэн бүртгэлийн дугаарыг өгч, “хавсралт-1” -ийн дагуу үндсэн бүртгэлд авна.

3.9.7 Бүртгэлийн үндсэн МК дугаарыг генетик материал тус бүрд давхардуулахгүй ашиглана. МК дугаарыг бусад интродукцийн, цуглуулгын, туршилтын ажлын болон үр сэргээн үржүүлэх үеийн дугааруудтай хольж хэрэглэж болохгүй.

### 3.10 Ургамлын генбанкийн менежментийн бүртгэл

3.10.1 Ургамлын генбанкид тодорхой дараалал, стандартын дагуу өдөр тутам хийгддэг бүх үйл ажиллагаатай холбоотой мэдээллүүдийг менежментийн бүртгэлд бүрэн хамруулж бүртгэнэ.

3.10.2 Ургамлын генбанкийн өдөр тутмын тогтмол үйл ажиллагаанд дараахь ажлуудыг ойлгоно. Үүнд:

- Шинэ генетик материалыг бүртгэх
- Генетик материалыг хог, хольцоос цэвэрлэх
- Генетик материалыг хатаах
- Генетик материалын амьдралтыг шалгаж тогтоох
- Генетик материалыг савлах, хадгалалтанд байрлуулах
- Генетик материалыг хадгалах явцад хяналт тавьж мониторинг хийх

- Морфологи, биологи, аж ахуй, биохими, генетикийн шинж тэмдгүүдээр судалж, үнэлгээ өгөх
- Генетик материалыг сэргээн үржүүлэх
- Генетик материалыг судалгаанд хуваарилах
- Генетик материалыг лаборатори, хүлэмж, ил талбайд тариалах арчлах, хураах технологийн үйлдлүүд

- Бусад

3.10.3 Ургамлын генбанкийн менежментийн бүртгэлийг тухайн генбанкийн хүчин чадал, хадгалж байгаа генетик материалын төрөл, онцлог, тоо хэмжээ зэргээс хамааруулан Генбанк бүр боловсруулж үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

3.10.4 НҮБ-ын ХХААБ-аас олон улсын хэмжээнд мөрдлөг болгож байгаа Генбанкийн стандартад тулгуурлан Ургамлын генбанкийн менежментийн бүртгэлийг боловсруулна.

3.11. Генетик нөөцийн судалгаа, үнэлгээний мэдээллийн бүртгэл

3.11.1 Генетик нөөцийн судалгаа, үнэлгээний мэдээллийн бүртгэл нь хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг таньж тодорхойлох, түүний биологи, аж ахуй, биохимийн онцлог шинжүүд, биотик болон абиотик тэсвэрийн шинжүүдийг илрүүлэх судалгаа болон генотипийн судалгаа зэрэг бусад судлагааны тоо, мэдээллээс бүрдэнэ.

3.11.2 Генетик нөөцийн судалгаа үнэлгээг энэхүү журмын 6.1 заасан мэргэжлийн судлаачид, ургамал тус бүрд зориулсан дескриптор ашиглан гүйцэтгэх бөгөөд судалгааны үр дүн, тоо өгөгдөл болон судлаачийн мэдээлэл бүхий тайланг холбогдох маягтын дагуу боловсруулж ургамал, газар тариалангийн туршилт, судалгааны ажил гүйцэтгэдэг төрийн үйлчилгээний эрдэм шинжилгээ хүрээлэнгийн дэргэдэх Генбанкийн бүртгэл хариуцсан нэгж болон ажилтанд хүргүүлнэ.

3.11.3 Судлаачдаас ирүүлсэн ургамлын генетик материалыг таньж тодорхойлох, онцлог, ашигтай шинжүүдийг илрүүлэх судалгааны үр дүн, тоо, бусад мэдээллийг Генбакийн бүртгэгч хүлээн авч генетик нөөцийн бүртгэл мэдээллийн системийн судалгаа, үнэлгээний мэдээллийн бүртгэлд загварын дагуу бүртгэнэ.

3.12 Генетик нөөцийн бүртгэлийн ажлын зохион байгуулалт

3.12.1 Хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл оруулах, засварлах, нэгтгэх, бусад оролцогч, хэрэглэгчдэд нэвтрэх эрх олгогч, тодорхой хязгаарлалт тогтоогч нь үндэсний бүртгэл мэдээллийн сангийн ерөнхий бүртгэгч байна.

3.12.2 Ерөнхий бүртгэгч нь мэдээллийн санд хандах хандалтыг бүртгэгч ба энгийн хэрэглэгч гэсэн 2 түвшнээр зааглана.

3.12.3 Мэдээллийн санд Ерөнхий бүртгэгчийн олгосон хандалтын түвшинд мэдээлэл оруулах, үр дүн гаргах, мэдээллийг архивлах, тайлан, мэдээ, лавлагаа, тодорхойлолт гаргах, баталгаажуулах, дамжуулах зэрэг үйл ажиллагааг бүртгэгчид хэрэгжүүлнэ.

3.12.4 Бүртгэгч нь нэвтрэх нэр, нууц үгээ бусдад ямар нэгэн хэлбэрээр дамжуулах, системийн нууц үг шалгагч программыг ажиллуулах, ажлаас чөлөөлөгдсөн, гарсан тохиолдолд нэгдсэн сангийн мэдээллийг бусдад тараахгүй байх ба холбогдох хууль, тогтоомжийн дагуу нууцын гэрээ байгуулж ажиллана.

3.12.5 Бүртгэгч нь ажлаас урт хугацааны чөлөө авах, хөдөлмөрийн гэрээ цуцлах тохиолдолд эзэмшиж байсан тоног төхөөрөмж, программ хангамж, зөөврийн төхөөрөмж, электрон байдлаар хадгалагдсан мэдээллүүд, хэвлэсэн баримт бичгүүд, гарын авлага зэрэг биет ба биет бус хөрөнгийг Генбанкийн эрхлэгчид хүлээлгэн өгнө.

3.12.6 Энэхүү журамд нарийвчлан тодорхойлсноос бусад ургамлын бүртгэлтэй холбоотой эрх, үүрэг, хариуцлага нь холбогдох хуулийн харилцаагаар зохицуулагдана.

Дөрөв. Хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг хадгалж хамгаалах,

4.1 Хүнс Хөдөө Аж Ахуйн Ургамлын Генетик Нөөцийн хадгалалтын төрөл

4.1.1 Ургамал, түүний үр, үндэс үр, булцуу, бусад ургал эрхтэн, ургамлын эд эс, ДНХ, тоос зэрэг ургамлын удамшлын мэдээллийг агуулж буй бүх төрлийн генетик материалыг генбанкид хадгална.


4.1.2 Ургамлын Генбанкийг түүнд хадгалж байгаа генетик материалын төрлөөс хамааруулан дараах байдлаар ангилна: Үүнд:

- Үрийн генбанк
- Талбайн генбанк
- Эдийн өсгөврийн генбанк
- Гүн хөлдөөж хадгалах генбанк
- ДНХ /Дезоксирибо нуклеин Хүчил/ генбанк

4.1.3 Генбанкид хадгалах генетик материалыг цэвэрлэх, хатаах, чийг тодорхойлох, амьдралтыг тодорхойлох, хадгалах, сэргээн үржүүлэх зэрэг өдөр тутмын үйл үйл ажиллагааг энэ журмын 8,2-д заасан эрдэм шинжилгээний хүрээлэнд боловсруулсан дэлгэрэнгүй аргачлалын дагуу гүйцэтгэнэ.

4.1.4 Генетик нөөцийг хадгалж байгаа зорилгоос хамааруулан Үндсэн цуглуулга, Ажлын цуглуулга ба Аюулгүй, нөөц цуглуулга гэж ангилж зохион байгуулна.

4.1.5 Үндсэн цуглуулга нь генбанкид ирсэн тухайн ургамлын генетик нөөцийн хамгийн анхны оригинал генетик материалуудаас бүрдэх бөгөөд зөвхөн хадгалах зориулалттай байна. Үндсэн цуглуулгад байгаа генетик материалыг аль болох хөндөхгүйгээр генетикийн бүрэн бүтэн байдлыг урт хугацаанд хамгаалах бөгөөд зайлшгүй тохиолдолд хамгийн цөөн давтамжаар сэргээн үржүүлж болно.



Зураг 1. Хүнс хөдөө аж ахуйн ургамлын генбанкийн үйл ажиллагааны зураглал

4.1.6 Ажлын цуглуулга нь генетик материалыг судлах, шинэ сорт гаргах, сургалтанд ашиглах болон сэргээн үржүүлэх зорилгоор тогтмол ашиглах зориулалттай генетик материалаас бүрдэнэ.

4.1.7 Аюулгүй, нөөц цуглуулга нь байгалийн болон бусад аюул, гамшиг, хохирол тохиолдохоос урьдчилан сэргийлж үндсэн цуглуулгын ижил хуулбар цуглуулгыг газарзүйн байршлын хувьд өөр газар байгуулж урт хугацааны горимоор зориулалтын дагуу хадгална.

4.1.8 Генбанкууд нь үндсэн ба ажлын цуглуулгын аль нэгийг эсвэл хоёуланг хадгалж болно.

## 4.2. Ургамлын үрийг генбанкид хадгалах

### 4.2.1 Үрийг цэвэрлэх

4.2.1.1 Үрийг түүний дагалдах бичиг баримтанд тулгуурлан генбанкийн цуглуулганд бүртгэж авсны дараа цэвэрлэнэ. Үр маш их чийгтэй эсвэл цэвэрлэгээг машинаар хийх бол үрийг гэмтэхээс сэргийлж цэвэрлэхийн өмнө 12% чийгтэй болтол хатаана.

4.2.1.2 Үрийн цэвэрлэгээг дараах дарааллаар гүйцэтгэнэ. Үүнд:

- хогт хольц, зэрэг гадны хольцоос үрийг салгах эхний цэвэрлэгээг. цэвэрлэх машинаар юмуу гараар хийнэ.

- Дараа нь хоосон үр, гэмтсэн үрийг түүх бөгөөд мөөгөнцөр ба хортон шавьжны гэмтэл, өндөг авгалдай зэрэг бохирдлыг гараар цэвэрлэнэ.

- Сүүлчийн цэвэрлэгээгээр механик гэмтэлтэй, үр хөврөлгүй, хорчгор үр, ижил төстэй хог ургамлын үр зэргээс цэвэрлэнэ.

4.2.1.3 Үрийн цэвэршилтийг дараах байдлаар тогтооно.

$$\text{Цэвэршилт (\%)} = \frac{\text{Цэвэр үрийн жин, г} \times 100}{\text{Ажлын дээжийн нийт жин, г}}$$

### 4.2.2 Үрийн чийгийн агууламжийг тодорхойлох:

Олон Улсын Үр Судлалын Холбооноос боловсруулсан олон улсын стандарт аргуудад тулгуурлаж үрийн чийгийн агууламжийг дараах дарааллаар тодорхойлно. Үүнд:

- Бүх төрлийн үр тариа, вандуй, шош, эрдэнэшиш мэтийн том үртэй таримлын үрийг буталсны дараа харин тэжээлийн олон наст өвснүүд, маалинга, байцаа, манжин мэтийн жижиг үртэй таримлын үрийн чийгийг шууд тодорхойлно.

- Үрийг цэвэрлэсний дараа чийгийн агууламжийг тодорхойлно.

- Чийгийг тодорхойлохын өмнө үрийн хэмжээ нь хадгалалтанд байх стандарт хэмжээнд хүрэх эсэхийг тооцсоны дараа илүү гарсан үрийг чийг тодорхойлоход ашиглана.

- Чийгийн хэмжээг Олон Улсын Үр Судлалын Холбооны 2005 оны аргачлалаар дараах байдлаар тооцно.

Үрийн чийгийн агууламж (% Нойтон жин) =  $\frac{\text{нойтон жин, г} - \text{хатаасны дараах жин, г}}{\text{Нойтон жин, г}} \times 100$

Үрийн чийгийн агууламж (% хуурай жин) =  $\frac{\text{нойтон жин, г} - \text{хатаасны дараах жин, г}}{\text{Хуурай жин, г}} \times 100$

- Үрийн чийг тодорхойлсон тухай тоо, мэдээг мэдээллийн санд бүртгэнэ.

### 4.2.3 Үрийг хатаах:

- Үрийг хатаах хүртэл агаарын чийгшил багатай, сайн агааржуулалттай сэрүүн нөхцөлд цаасан уут, хөвөн даавуун уутанд түр хадгална.

- Үрийн амьрах чадварыг бууруулахгүйгээр хатаах хамгийн тохиромжтой нөхцөл буюу 10-25%-ийн агаарын харьцангуй чийгтэй, 15-20<sup>0</sup>С-ын температуртай орчинд аажмаар хатаах аргыг хэрэглэнэ. Мөн чийг шингээгч цахиурын исэл эсвэл агаар чийггүйжүүлэгч зэрэг тоног төхөөрөмж ашиглаж болно.

- Үрийн Генбанкид үр хадгалах стандарт чийгийн агууламж нь үндсэн цуглуулгад 5-8%, ажлын цуглуулгад 7-10%-аас илүүгүй байна.

- Үр хатаалтын тухай бүх тоо мэдээг мэдээллийн санд бүртгэж хадгална.

### 4.2.4 Үрийн амьдрах чадварыг тодорхойлох:

- Үрийн амьдрах чадварыг генбанкид үрийг уутлаж байрлуулахын өмнө бас хадгалалтын явцад тодорхой үечлэлээр, стандарт аргачлалын дагуу тодорхойлно.

- Генбанкид үрийг хүлээн авмагц үрийг цэвэрлэж, хатаасны дараа анхны үрийн амьдрах чадварыг шалгана.

- Үрийн амьдрах чадвар 85%-иас доош байвал түүнийг дахин цуглуулах, эсвэл сайн чанартай үр авахаар тариалж сэргээн үржүүлэх арга хэмжээ авна.

- Үрийн амьдрах чадварыг түүний лабораторийн соёлолтыг тодорхойлох замаар тогтооно. Соёлолт шалгах тогтсон хэмжээ нь 50ш үрээр 2 давталтаар нийт 100ш үр ашиглаж соёлолтыг тодорхойлно.

- Үрийн амьдрах чадварыг тодорхойлсон арга, үр дүнгийн тухай тоо мэдээг мэдээллийн санд бүртгэж хадгална.

#### 4.2.5 Үрийг савлах:

- Үрэнд ус чийг нэвчих, болон өвчин, хортон бусад халдвар, бохирдлоос хамгаалах, өөр үртэй холихгүй байх зорилгоор үрийг хатаасны дараа шууд савалж битүүмжилнэ. Бүрэн боловсорсон, 100% цэвэршилтгэй, 10%-аас доош чийгийн агууламжтай үрийг савлана.

- Үрийн генбанкийн хадгалалтын нөхцөл, хадгалж байгаа ургамлын төрөл, зүйлийн онцлогоос шалтгаалан үрийг савлах савыг сонгоно. Үрний уут сав нь ус нэвтрүүлдэггүй, хөлдөлтөнд тэсвэртэй, битүүмжлэл сайн, шилэн болон хөнгөн цагаан сав, тугалган уут зэргийг ашиглана.

- Үрийн уут, сав дотор болон гадна талд тухайн дээжийн бүртгэлийн МК дугаар, ургамлын болон сортын нэр, хадгалалтанд орсон огноо зэрэг мэдээллийг бичсэн байна.

#### 4.2.6 Үрийг хадгалах:

- Үрийн генбанкийн үндсэн цуглуулгыг  $-18^{\circ}\text{C}$   $-20^{\circ}\text{C}$ -д, агаарын харьцангуй чийг  $15 \pm 3\%$  нөхцөлд урт хугацаагаар хадгална. Мөн гүн хөлдөөж хадгалах генбанкид тусгай бэлтгэгдсэн эд эсийн өсгөврийг шингэн азотод  $-196^{\circ}\text{C}$ -д удаан хугацаагаар хадгална.

- Үрийн генбанкийн ажлын цуглуулгыг  $5^{\circ}$ - $10^{\circ}\text{C}$  хэмд, агаарын харьцангуй чийгшил  $15 \pm 3\%$  нөхцөлд хадгална.

- Үрийн дээж бүрийг хадгалах хөлдөөгч, агуулах, тавиур, сагс, шүүгээний байршлыг илэрхийлсэн код зохиож ашиглана.

- Хадгалж байгаа үрийн дээж тус бүрийн бүртгэлийг журмын 3-д заасны дагуу бүртгэх ба холбогдох мэдээллийг мэдээллийн санд хадгална.

- Морфологи шинжээрээ ижил төстэй, генетикийн хувьд гомозигот дээжийн 3000-4000 ш үр, харин морфологийн маш олон шинж тэмдэг илэрдэг, генетикийн хувьд гетерозигот ургамлын дээж тус бүрд 4000-12000 ш үр хадгална. Дээж тус бүрийг хадгалах үрийн хэмжээг тухайн ургамлын 1000 үрийн жинд үндэслэн жингээр тооцож болно.

#### 4.2.7 Үрийн хадгалалтын үеийн мониторинг:

- Үрийг хадгалах явцад үрийн амьдрах чадвар буурах, үрийн тоо хэмжээ багасах, янз бүрийн өвчин, хортонд идэгдэх зэрэг өөрчлөлтүүд гарч байгаа эсэхэд генбанкийн менежер тогтмол хяналт тавьна.

- Үндсэн цуглуулгад хадгалж байгаа үрийг 10 жил тутамд, харин ажлын цуглуулгад хадгалж байгаа үрийг 5 жил тутамд тус тус дээж тус бүрийн үрийн тоо, хэмжээ, үрийн амьдрах чадварыг тодорхойлох замаар хяналт тавьна.

- Цуглуулга дахь үрийн соёлолт 85%-аас доош, үрийн хэмжээ 3 удаа сэргээхэд хүрэлцэхгүй хэмжээнд хүрсэн тохиолдолд үрийг хадгалалтаас гаргаж сэргээн шинэчлэх, үржүүлэх арга хэмжээ авна.

- Хадгалалтын үеийн үрийн мониторинг хийсэн тухай мэдээллийг тухай бүрд нь мэдээллийн санд хадгална.

### 4.3 Генетик нөөцийн хадгалалтын бусад төрлүүд

#### 4.3.1 Талбайн генбанк

- Үрээр хадгалахад тохиромж муутай, олон наст ургамал, мод бутыг талбайд ургаагаар хадгална.

- Хөрсний бүтэц, үржил шим сайн, усны эх үүсвэр хангалттай, салхигүй, нөмөр, цаг уурын нөхцөл тогтвортой, зөөлөн уур амьсгалтай, ирээдүйд өргөжүүлэх боломжтой хангалттай нөөц бүхий газрыг сонгож талбайн генбанкийг байгуулна.

- Ургамлын төрлөөс шалтгаалж талбайн генбанкид хадгалах ургамлын тоог генбанкийн аргачлалын дагуу сонгоно.

- Талбайн генбанкид хадгалж байгаа ургамлын дээжүүдийн байршлын маш сайн зураг заавал хийсэн байна. Дээж тус бүрийг хаягжуулж бат бөх хаяг, шошгууд хийж ургамлаас өлгөх буюу сайн гадасласан байна.

- Ургамал ургалтын хугацаанд олон наст ургамлуудыг услах, хог ургамалтай тэмцэх, өвчин хортноос хамгаалах ажлыг ургамлын төрөл, зүйл тус бүрийн онцлогт тохируулан технологийн горимыг баримтлан гүйцэтгэнэ.

- Талбайн генбанкид хадгалж байгаа дээж бүрийн нэг хувилбарыг өөр газар оронд аюулгүй нөөц цуглуулга хэлбэрээр байгуулна. Эсвэл эдийн өсгөвөр болон гүн хөлдөөж аюулгүй нөөц цуглуулга хэлбэрээр хадгална.

#### 4.3.2. Эдийн өсгөврийн генбанк

- Ургамлын ургал эрхтнээр үрждэг эсвэл үр үүсдэггүй ургамлын төрөл зүйлүүдийг / төмс, ихэнх жимс, жимсгэнэ, чимэглэлийн мод бут, гэх мэт/ үр хөврөл, оройн меристем эд, далд нахиаг лабораторийн нөхцөлд ургуулах замаар тусгай тэжээлт орчинд эдийн өсгөврийн аргаар хадгална.

- Вегетатив буюу үржлийн ургал эрхтэнээр үрждэг ургамлын генетик нөөцийг эдийн өсгөврийн аргаар хадгалах үндсэн 2 чиглэл байна.

1. Эд, эсийн өсгөврийн ургалтыг удаашруулах
2. Шингэн азотод гүн хөлдөөж (-196°C)-д хадгалах

Тав. Хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг сэргээн үржүүлэх

5.1 Ургамлын генетик нөөцийг урт хугацаанд найдвартай амьдаар хадгалахын тулд түүний генетик материалыг тодорхой давтамжаар ургуулж тухайн генетик материалын үндсэн шинж тэмдэгийг бүрэн хадгалсан шинэ генетик материал хурааж авах замаар ургамлын генетик нөөцийг сэргээн үржүүлнэ.

5.2 Ургамлын генетик нөөцийг сэргээж үржүүлэх ажлыг энэ журмын 8.2-д заасан төрийн үйлчилгээний эрдэм шинжилгээний байгууллага нь мэргэжлийн бусад байгууллага, судлаачтай хамтран гүйцэтгэнэ. Төрийн үйлчилгээний эрдэм шинжилгээний байгууллага нь ургамал тус бүрийг сэргээн үржүүлэх технологийн аргачлал ба үр бусад материалаар судлаачдыг хангах, үр дүнг нарийн тооцох гэрээ байгуулж ажиллана.

5.3 Энэ журмын 8.2 заасан төрийн үйлчилгээний эрдэм шинжилгээний байгууллага нь ургамлын генетик нөөцийг сэргээж үржүүлэх аргачлалыг ургамал тус бүрийн онцлогт тохируулж, олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж баталгаажуулна.

5.4 Жил бүрийн эхэнд тухайн жилд сэргээн үржүүлэх шаардлагатай генетик материал, дээжүүдийн жагсаалтыг таримал тус бүрээр гаргаж, сэргээн үржүүлэх ажлыг зохион байгуулах төлөвлөгөө, зарцуулах зардлын тооцоог генбанкийн менежер боловсруулж эрдэм шинжилгээний байгууллагын захирлаар батлуулж хэрэгжүүлнэ.

5.5 Ургамлын генетик нөөцийг сэргээн үржүүлэхэд дараах хүчин зүйлүүдийг дагаж мөрдөнө. Үүнд:

- Тухайн генетик нөөцийн үндсэн шинж чанарыг алдахгүйн тулд аль болох цөөн удаа сэргээн үржүүлэх арга хэмжээ авах,

- Нэг удаагийн тариалалтаар үндсэн, ажлын болон аюулгүй нөөц цуглуулгуудад хадгалахад хүрэлцэхүйц хэмжээний генетик материал бүрдүүлэх зорилгоор их хэмжээний генетик материал үржүүлэх буюу хамгийн багадаа 3 удаа сэргээн үржүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээтэй материал хураан авах,

- Хамгийн эхний ээлжинд үр болон ургамлын материалын амьдрах чадвар стандарт түвшинээс буурсан дээжүүдийг, дараагийн ээлжинд нөөц багатай буюу ургамлын генетик материалын хэмжээ нь хадгалахад хүрэлцэхгүй байгаа материалуудыг, хамгийн сүүлд амьдрах чадвар сайтай боловч бага, цөөн үртэй дээжүүдийг сэргээн үржүүлэх дарааллаар гүйцэтгэнэ.

- Гадаадаас шинээр ирсэн шинэ үр ба материалуудыг анх удаа тариалж байгаа бол ургамлын хорио цээрийн тусгаарлагдсан орчинд тариалж сэргээх үйл ажиллагааг зохион байгуулна.



- Ургамлын үр бусад генетик материалыг ургуулж чадахгүйгээс болж алдах эрсдлийг багасгахын тулд хамгийн үржил шим сайн хөрсний хэв шинжтэй, хангалттай усны нөөцтэй, тохиромжтой дулаан, гэрлийн хангамжтай, элдэв ургамлын өвчин, хөнөөлт хортон, шавьжны эх үүсвэрээс зайтай, тухайн ургамал ургах тааламжтой нөхцөл бүрдсэн газрыг сонгоно.

- Солибцон тоос хүрдэг ургамлуудын дээжийг сэргээн шинэчлэх тохиолдолд зайн тусгаарлалт хийх ба чанартай үр авахад эр, эм ургамлын хамгийн тохиромжтой харьцааг тогтооно. Зайн тусгаарлалтын зай хэмжээг ургамлын төрлөөс хамааруулан тогтооно.

- Тухайн ургамлын генетик материалын үндсэн бүх шинж тэмдгүүд болон популяцийг бүрэн төлөөлж чадах хамгийн тохиромжтой ургамлын тоог тогтоож, хангалттай хэмжээгээр сонгоно.

5.6 Шинэчлэн үржүүлсэн үр, ургамлын бусад дээж нь хогт хольц бусад хорхой шавьж, өвчнөөс 100% цэвэрлэгдсэн, 95-ээс дээш хувийн лабораторийн соёлолттой, үрийн чийгийг 7%-10%-иас ихгүй байхаар хатаасан байх шаардлагатай.

5.7 Сэргээн үржүүлэх явцад хийсэн ажиглалт, судалгааны мэдээллийг аргачлалын дагуу бүртгэж хадгална.

Зургаа. Хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг судалж, үнэлэх

6.1 Хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик материалыг судалж, үнэлэх үйл ажиллагааг энэхүү журмын 8.2 заасан хуулийн этгээд зохион байгуулах бөгөөд холбогдох мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

6.2 ХХААУГН-ийг судалж, үнэлэх үйл ажиллагааг дотор нь ургамлын генетик нөөцийг таньж тодорхойлох, тэдгээрийн төлөв байдлыг тогтоох болон ашигтай шинж чанаруудыг илрүүлэх чиглэлүүдээр ангилж зохион байгуулна.

6.3 ХХАА-н ургамлын фенотип, генотип, тэсвэрийн, биохимийн шинж тэмдгүүдийн илэрлийг лабораторийн болон хээрийн туршилт судалгаа гүйцэтгэх явцад төрөл бүрийн ургамлын дескриптор ашиглан бичиглэл хийж, үнэлгээ өгөх замаар ургамлын генетик материалыг судалж үнэлэх ажлыг гүйцэтгэнэ.

2.25 6.4НҮБ-ын ХХААБ болон Биологийн олон янз байдлын олон улсын байгууллага болон ОУҮСХ - Олон Улсын Үр Судлалын Холбооны боловсруулсан ургамлын олон улсын нийтлэг стандартуудыг ашиглаж тухайн ургамал тус бүрийг тодорхойлох, судалж үнэлэх дескрипторууд болон судалгааны аргачлалуудыг ургамлын судалгаагаар мэргэшсэн эрдэм шинжилгээний байгууллагууд бие дааж болон хамтран боловсруулж эрдмийн зөвлөлөөр баталгаажуулж ашиглана.

6.5 Ургамлын генетик нөөцийг судалж, үнэлэх судалгааг тухайн генетик материалыг генбанкид ирсэн даруйд хийж гүйцэтгэх шаардлагатай бөгөөд эсвэл тухайн генетик материалыг сэргээн үржүүлэх ажилтай хамтатган гүйцэтгэж болно.

6.6 Хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг судалж, үнэлэх ажлыг улсын төсвийн болон хуулийн этгээдийн санхүүжилтээр гүйцэтгэнэ.

6.7 Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн судалгаа, туршилтын үр дүн, мэдээллийг хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн мэдээллийн үндэсний санд заавал бүртгүүлнэ.

6.8 Судалгаа, туршилтын үр дүнд бий болсон шинэ сорт, ашигтай загвар, технологийг бүртгүүлэх, өмчлөх, дамжуулах тохиолдолд Монгол Улсын бусад холбогдох хууль, дүрэм журмын заалтыг мөрдөнө.

6.9 Хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн төрөл, зүйлийн өвөрмөц шинж чанарыг гадаадын болон дотоодын эрдэм шинжилгээний байгууллага, лабораторитай хамтран тодорхойлох, судлах тохиолдолд хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг шилжүүлэх, судлах талаар гэрээ заавал байгуулна.

Гэрээнд дараах нөхцлийг тусгана:

- хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн судалгаа туршилт явуулах үндэслэл, зорилго;

- хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн төрөл, зүйлийн нэр, тоо хэмжээ;
- хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн гарвал;
- судалгааг явуулах хугацаа;
- биоаюулгүй байдлыг хангах зохицуулалт;
- оюуны өмчийн эрхийн зохицуулалт, технологи дамжуулах нөхцөл;
- хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг судалснаас хүлээж буй үр дүн, ашиг хүртэх хэлбэр;
- маргаан шийдвэрлэх зохицуулалт;

Долоо. Хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг хуваарилах, цуглуулах

7.1 Төрийн үйлчилгээний эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Үндэсний Генбанкаас хүнс хөдөө аж ахуйн ургамлын үр болон ургамлын бусад генетик материалыг дараах зориулалтаар хуваарилна. Үүнд:

- ургамлын туршилт, судалгаа хийх, селекцийн эх материал бэлдэх
- ургамлын генетикийн материалыг шинэчилж үржүүлэх
- гадаад болон дотоодын байгууллагуудтай зөвхөн судалгаа хийх, шинэ сорт гаргах, сургалтанд ашиглахад зориулж генетикийн материал солилцох

• ургамлын генетик нөөцийг Аюулгүйн нөөц цуглуулгад хадгалах

7.2 Ургамлын генетик материалын дээжийг ажлын цуглуулгаас хуваарилахад дараах зарчим баримтална. Үүнд:.

• Гадаадын захиалагчийн хүсэлтийн дагуу дээж илгээх болон харилцан солилцох нөхцөлд нэг удаагийн дээжийн хэмжээг баримтална.

• Нэг удаагийн дээжийн хэмжээг тухайн ургамлын онцлог, тоо, хэмжээ зэргийг харгалзан дээж тус бүрээс 100 ш хүртэл үр бусад генетик материал хуваарилж болно.

• Дотоодын захиалагчийн хүсэлтээр судалгааны онцлог, цар хүрээг харгалзан судалгаанд зориулж гаргах генетик материалын хэмжээ дээд тал нь 1м<sup>2</sup> талбайд тарихад хүрэлцэхүйц хэмжээтэй байна.

• Захиалгын дагуу генетик материалыг хуваарилахын өмнө ажлын цуглуулгад 3 удаа үрийг сэргээхэд хүрэлцэхүйц үр үлдсэн байх шаардлагыг харгалзаж үр, бусад материал гаргах эсэхийг шийдвэрлэнэ. Хэрэв үр стандарт хэмжээнд хүрэлцэхгүй хэмжээтэй байвал үрийг дахин тариалж сэргээсний дараа захиалагчид илгээх бөгөөд энэ тухай захиалагчид мэдэгдэнэ.

• Генбанкид хадгалж байгаа генетик материалын онцлог, гарал үүсэл, хууль эрх зүйн хориг, хязгаар зэрэг нөхцлүүдийг харгалзан гадаад улсын байгууллагуудтай судалгааны зорилгоор харилцан солилцох, хуваарилах боломжтой дээжийн жагсаалтыг Генбанк гаргана.

7.3 Үндсэн цуглуулгаас зөвхөн доорхи тохиолдлуудад ургамлын генетик материалыг хуваарилна. Үүнд:

• Үндсэн цуглуулгад хадгалж байгаа дээжүүдийн лабораторийн соёлолт стандарт хэмжээнээс доош (85%) болж буурсан тохиолдолд үр, ургамлын бусад материалыг хадгалалтаас гаргаж дахин тариалж сэргээх,

• Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр ажлын цуглуулгад генетикийн материалын нөөц стандарт хэмжээнээс эрс багассан болон нөөцгүй болсон онцгой тохиолдолд түүнийг нөхөх зорилгоор үр, ургамлын бусад материалыг үндсэн цуглуулгын хадгалалтаас гаргаж тариалж үржүүлэх,

• Үндсэн цуглуулгаас Аюулгүйн нөөц цуглуулгад зориулж дээж хуваарилах,

7.4 Генбанкаас генетик материал авах хүсэлтийг энэ журмын 8.2 заасан эрх бүхий төрийн үйлчилгээний эрдэм шинжилгээ байгууллагад захиалагч албан тоотоор албан ёсоор гаргана.

7.5 Эрдэм шинжилгээ байгууллага нь тухайн генетик материалыг хуваарилах боломжтой эсэхийг холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд судалж үзээд ажлын 10 хоногт багтаан хариу өгнө.

7.6 Албан хүсэлтийн дагуу ургамлын генетик нөөцийг олгох боломжтой шийдвэр гарсаны дараа ургамлын генетик материалыг олгож хуваарилах гэрээ байгуулна.

7.7 Олон улсын гэрээний Олон Талт Тогтолцоонд хамрагдсан ургамлын хувьд гэрээг Хавсралт 2-д заасан Стандарт Материал Дамжуулах Гэрээ (СМДГ)-ний нөхцлөөр хийнэ. СМДГ-г энэхүү журмын 8.2 заасан эрдэм шинжилгээний байгууллага байгуулна.

7.8 Монгол улсын олон улсын гэрээ “Хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн олон улсын гэрээ”-ний зорилтуудыг хэрэгжүүлж зөвхөн хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр судалгаа шинжилгээнд, шинэ сорт гаргахад, сургалт хийхэд тус тус ашиглах зорилгоор ургамлын генетик материалын хуваарилах, харилцан солилцоход энэхүү Олон Улсын Гэрээний холбогдох заалтууд, Гэрээний Хавсралт 1-д байгаа ургамлын жагсаалт болон жишиг Стандарт Материал Дамжуулах Гэрээ баримтална /Хавсралт 2 ба 3/. Харин химийн, эмийн эсвэл бусад хүнсний бус бүтээгдэхүүн, тэжээлийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах генетик материалд энэ заалт хамаарахгүй.

7.9 Хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик материалыг судалгаа шинжилгээнд, шинэ сорт гаргахад, сургалт хийх зорилгоор экспортлох, импортлох зохицуулалтыг монгол улсын холбогдох хууль, нийтээр дагаж мөрдөх журам, стандарт болон энэхүү журмын заалтуудыг мөрдлөг болгоно.

7.10 Эрдэм шинжилгээ, судалгааны зорилгоор гадаадаас оруулах, гадаадад илгээх ургамлын генетик материалыг тухайн тарималд тогтоосн экспорт, импортын квотоос чөлөөлнө. Квотоос чөлөөлөх, судалгаанд зориулсан генетик материалын дээж тус бүрийн хэмжээ 5 кг-аас ихгүй байна.

7.11 Ургамлын генетик материалыг хуваарилж, тээвэрлэхдээ тухайн материал амьдрах чадвараа хэвийн хадгалах боломжтой, чийг нэвтэрдэггүй, битүүмжилсэн, тугалган уутанд савлаж, уутны гадна болон дотор талд бүртгэлийн дугаар, ургамлын нэр, шинжлэх ухааны нэр, сортын нэр, гарал, он зэрэг мэдээлэл бүхий шошгыг хийсэн байна.

7.12 Ургамлын генетик материалыг илгээхдээ тээвэрлэлтийн хамгийн аюулгүй бөгөөд хурдан, шулуун замыг сонгох ба тээвэрлэлтийг мөрдөх цахим систем бүхий буухиа шуудангийн үйлчилгээг ашиглана.

7.14 Хүнс, хөдөө аж ахуйн таримал ургамлын генетик нөөцийг цуглуулж, баяжуулах

7.14.1 Хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг цуглуулж, баяжуулах ажлыг уэнэ журмын 8.2 заасан ургамал, газар тариалангийн судалгааны эрдэм шинжилгээний хүрээлэн бие дааж болон бусад эрдэм шинжилгээний хүрээлэн, их сургууль, судалгааны байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

7.14.2 Бусад хүрээлэн, их сургууль, байгууллагууд бие дааж цуглуулга хийж болох бөгөөд харин шинээр цуглуулсан хүнс хөдөө аж ахуйн генетик материалын тодорхой хэсгийг Үндэсний Генбанкид хадгалуулж, мэдээллийг бүртгүүлнэ.

7.14.3 Хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг цуглуулж, баяжуулах ажлыг дараах хэлбэрээр гүйцэтгэнэ. Үүнд:

- Гадаад, дотоодын генбанк, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, их дээд сургууль, олон улсын судалгааны төвүүд, үрийн аж ахуйнууд, тариаланчид болон бусад эх үүсвэрээс хүнс хөдөө аж ахуйн ургамлын сортууд тэдгээрийн бусад хэлбэрийг харилцан солилцох, захиалах, худалдан авах,

- Хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг цуглуулах дотоодын болон гадаадын экспедици зохион байгуулах,

- Дипломат харилцаа, албан томилолт, худалдаа арилжаа, аялал жуучлалаар явагсад, суралцагсад зэргээр дамжуулан төрөл бүрийн ургамлын генетик материалын цуглуулга хийх,

- Бусад

7.14.4 Шинээр цуглуулсан сорт, бусад дээж материалыг энэхүү журмын 3 бүлгийн дагуу бүртгэж генбанкад хүлээн авна.

8. Удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

8.1 Монгол улсад хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг бүртгэх, мэдээллийн систем хөтлөх, генетик нөөцийг амьдаар хадгалж хамгаалах, сэргээн үржүүлэх судлах, хуваарилах, цуглуулах үйл ажиллагааны бодлого зорилтыг боловсруулах, төлөвлөх, удирдан зохион байгуулах чиг үүргийг улсын хэмжээнд Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 28,1 зүйлд заасан тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

8.2 Хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг бүртгэх, мэдээллийн систем хөтлөх, генетик нөөцийг амьдаар хадгалж хамгаалах, сэргээн үржүүлэх судлах, хуваарилах, цуглуулах үйл ажиллагааг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүргийг тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилсон ургамал, газар тариалангийн туршилт, судалгааны ажил гүйцэтгэдэг төрийн үйлчилгээний эрдэм шинжилгээний хүрээлэн хариуцна.

8.3 Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн бүтцэд хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн менежментийг хариуцсан Үндэсний Генбанк ажиллана. Генбанкийн өдөр тутмын үйл ажиллагааг Генбанкийн менежер хариуцаж зохион байгуулна.

8.4 Энэ журмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нийтлэг аргазүй, аргачлалыг олон улсад мөрдөж байгаа стандарт, журамд нийцүүлэн боловсруулж баталгаажуулах ажлыг энэ журмын 8.3 заасан Үндэсний Генбанк гүйцэтгэнэ.

8.5 хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг бүртгэх, мэдээллийн систем хөтлөх, генетик нөөцийг амьдаар хадгалж хамгаалах, сэргээн үржүүлэх судлах, хуваарилах, цуглуулах, зэрэг Үндэсний Генбанкид гүйцэтгэх судалгааны зардал, хөрөнгө оруулалтыг ургамал, газар тариалангийн чиглэлээр туршилт, судалгаа гүйцэтгэдэг төрийн үйлчилгээний эрдэм шинжилгээ хүрээлэнгийн төсөвт жил бүр хуваарилж Засгийн газар шийдвэрлэнэ. Мөн, гадаад, дотоодын, хамтарсан төсөл, хөтөлбөр, тусламж зэрэг бусад санхүүгийн эх үүсвэрээр санхүүжүүлж болно.

## Таримал ургамлын нийтлэг паспортын бүртгэл

1. Хүрээлэнгийн код Ургамлын дээж хадгалж байгаа хүрээлэнд НҮБ-ын ХХААБ-аас олгосон олон улсын код. ISO 3166 –д бүртгэгдсэн тухайн улсын нэрний 3 үсгийн товчлол бүхий улсын нэр болон эрдэм шинжилгээний хүрээлэнгийн дугаарыг агуулна (Жишээлбэл Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн олон улсын бүртгэлийн дугаар MNG 030). .
2. Дээжийн бүртгэлийн дугаар Генбанканд хадгалагдаж байгаа болон хадгалалтанд шинээр орж байгаа дээжинд өгдөг дахин давтагдашгүй дугаар. Жишээ нь: Монгол каталог МК 01
3. Цуглуулгын дугаар Тухайн дээжийг анх цуглуулсан хүний өгсөн дугаар. Ихэвчлэн цуглуулсан хүний нэр эсвэл нэрний үсэг түүн дээр тоо залгаж дугаарласан байдаг.
4. Цуглуулгыг хийсэн хүрээлэнгийн код
4.1 Цуглуулга хийсэн хүрээлэнгийн нэр НҮБ-ын ХХААБ-аас олгосон код бүхий албан ёсны нэр ашиглах ба ийм код байхгүй бол хүрээлэнгийн нэрийг ашиглана.
4.1.1 Цуглуулга хийсэн хүрээлэнгийн хаяг
4.2 Цуглуулгын экспедицийн нэр, дугаар
5. Таримлын төрлийн нэр. Эхний үсэг томоор бичигдэнэ.
6. Зүйл Шинжлэх ухааны нэр жижиг үсгээр бичнэ..
7. Шинжлэх ухааны ангилал зүйн дэд бүлэг Дэд бүлэг нь таксономийн нэмэлт ангилал байна.
8. Таримлын оноосон нэр. Таримлын түгээмэл ашигладаг нэр.
9, Дээжийн буюу сортын нэр
10. Бүртгэсэн огноо Хадгалалтанд орсон дээжийн он, сар, өдрийг тэмдэглэн бичнэ. Тодорхойгүй бол – эсвэл 00 гэж тэмдэглэнэ.
11. Гарал Улсын нэрийг ISO 3166 –д заасан 3 үсгийн товчлолоор тэмдэглэнэ. Тухайн материал сорт, эсвэл эрлийз, селекцийн дугаар эсэхийг тэмдэглэх.
12. Дээж цуглуулсан газрын байршил Дээж цуглуулсан газрын мэдээллийг оруулна. Хамгийн ойр орших сумаас хэдэн километр зайд орших, газрын зураг, чиглэл зэрэг мэдээллийг агуулсан байж болно.
13 Газарзүйн солбицол, уртраг, өргөрөгийн мэдээлэл
14. Далайн түвшинээс өргөгдсөн өндөр
15 Дээж цуглуулсан огноо Дээжийг цуглуулсан он, сар, өдрийг тэмдэглэн бичнэ. Тодорхойгүй бол – эсвэл 00 гэж тэмдэглэнэ.

16. Дээжийг бүтээсэн хүрээлэнгийн код  
НҮБ-ын ХХААБ-аас олгосон код бүхий албан ёсны нэр ашиглах ба ийм код байхгүй бол хүрээлэнгийн нэрийг ашиглана

16.1 Дээжийг бүтээсэн хүрээлэнгийн нэр

17. Дээжийн биологийн төлөв  
100 Зэрлэг  
110 Байгалийнн  
120 Байгалийн болон зэрлэг  
130 Байгалийн болон тариалсан  
200 Хогийн зэрлэг ургамал  
300 Нутгийн таримал сорт  
400 Селекцийн судалгааны материал  
410 Эрлийз удам  
411 Синтетик популяци  
412 Гибрид  
413 Үндсэн популяци  
414 Инбред удам /Гибридийн эх эцэг /  
415 Задарч байгаа популяци  
416 Клоны сонголт  
420 Генетик эх материал  
421 Мутант  
422 Цитогенетикийн материалууд  
423 Бусад генетик материалууд  
500) Орчин үеийн сайжруулсан сортууд (уламжлалт селекцийн аргаар)  
600) бусад

18. Удамшлын мэдээлэл. Удамшил, гарлын мэдээлэл ( мутац, селекцэд ашигласан дээж).

19. Цуглуулгын эх үүсвэр  
10 Зэрлэг байгаль  
11 Ой  
12 Бут, сөөглөг газар  
13 Хээр  
14 Цөл  
15 Ус  
20 Ферм, тариалсан газар,  
21 Тариалангийн талбай  
22 Жимсний аж ахуй  
23 Өрхийн цэцэрлэг  
24 Уринш  
25 Бэлчээр  
26 Зоорь  
27 Үтрэмийн талбай  
28 Цэцэрлэгт хүрээлэн  
30 Дэлгүүр  
40 Хүрээлэн, туршилтын цэг, судалгааны байгуулга, генбанк  
50 Үрийн компани  
60 Хог ургамалтай талбай  
61 Замын хажуу  
62 Талбайн зах  
99 бусад

20. Донор хүрээлэнгийн код
21. Донор хүрээлэнгийн нэр
22. Донор хүрээлэнгийн дээжийн дугаар
23. Дээжтэй холбоотой бусад мэдээлэл
24. Олон улсын гэрээний Даян дэлхийн мэдээллийн системийн ургамлын генетик нөөцтэй холбоотой Дижитал объект тодорхойлогч мэдээллийн сантай холбох
25. Аюулгүй нөөц цуглуулгын байршил.
26. Аюулгүй нөөц цуглуулгыг хадгалж буй хүрээлэнгийн нэр. НҮБ-ын ХХААБ-аас олгосон код бүхий албан ёсны нэр ашиглах ба ийм код байхгүй бол хүрээлэнгийн нэрийг ашиглана
27. Генетик нөөцийн хадгалалтын төрөл 10 Үрийн цуглуулга 11 Богино хугацааны хадгалалт 12 Дунд хугацааны хадгалалт 13 Урт хугацааны хадгалалт 20 Талбайн цуглуулга 30 Эдийн өсгөврийн/ цуглуулга 40 Гүн хөлдөөсөн цуглуулга 50 ДНХ цуглуулга 99 бусад
28. Олон Талт Тогтолцоонд хамрагдсан эсэх Хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн олон улсын гэрээний Олон Талт Тогтолцоо (ОТТ) –д хамрагдсан эсэх. Статус нь мэдэгдэхгүй бол утгыг хоосон орхино.. 0 үгүй 1 тийм 99 Бусад

## СТАНДАРТ МАТЕРИАЛ ДАМЖУУЛАХ ГЭРЭЭ /ЖИШИГ/

## ОРШИЛ

Хүнс Хөдөө Аж Ахуйн Ургамлын Генетик Нөөцийн Олон Улсын Гэрээ (үүнээс хойш “Гэрээ” гэх)<sup>1</sup> нь НҮБ-ын ХХААБ-ын 31 дэх удаагийн бага хурлаар 2001 оны 11 сарын 3 өдөр батлагдсан бөгөөд 2004 оны 6 сарын 29 өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн байна. Гэрээний зорилго нь Хүнс Хөдөө Аж Ахуйн Ургамлын Генетик Нөөцийг хадгалах, тогтвортой ашиглах түүнийг ашигласнаас үүссэн үр ашгийг Биологийн Олон Янз Байдлын Конвенцийн зарчимтай уялдуулан шударга, тэгш хуваарилах замаар хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил, хүнсний аюулгүй байдлыг хангах явдал юм.

Гэрээнд нэгдсэн талууд нь бүрэн эрхийнхээ хүрээнд, хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг ашиглах эрх олгох, түүнийг ашигласнаас бий болох ашгийг шударга, тэгш хуваарилах арга замыг хэрэгжүүлэх хамгийн үр ашигтай, үр дүнтэй, ил тод Талуудын Эрх, Тэгш Оролцоог хангасан тогтолцоог бүрдүүлэхэд харилцан хүчин чармайлт гаргахаар тохиролцоонд хүрэв.

Гэрээний 4, 11, 12.4 ба 12.5 дугаар заалтуудад;

Гэрээнд нэгдсэн талуудын дотоодын шүүх, арбитрын засаглал, төдийгүй олон улсын болон бүс нутгийн бусад гэрээ, хэлэлцээрт баримталдаг дүрэм журмууд харилцан адилгүй байгааг харгалзаж;

Гэрээний 12.4 дүгээр зүйлд: ургамлын генетик нөөцийг ашиглах эрхийг хөнгөвчилж олгоход Гэрээний Удирдах Байгууллагын 2006 оны 6 сарын 16 өдрийн 1/2006 тоот шийдвэрээр баталсан Стандарт Материал Дамжуулах Гэрээг мөрдлөг болгохоор заасан байна.

## ЗҮЙЛ 1 – ГЭРЭЭНД НЭГДСЭН ТАЛУУД

1.1 Энэхүү Материал Дамжуулах Гэрээ нь (үүнээс хойш “Гэрээ” гэх) Олон улсын гэрээний 12.4 дүгээр зүйлд заасан Стандарт Материал Дамжуулах Гэрээ юм.

1.2 Энэ “Гэрээг” дараах хуулийн этгээд хооронд байгуулна:

НИЙЛҮҮЛЭГЧ: (нийлүүлэгч буюу нийлүүлэгч хүрээлэнгийн нэр хаяг, албан ёсны хүний нэр, холбогдох мэдээлэл) (цаашид “Нийлүүлэгч гэх”)

ХҮЛЭЭН АВАГЧ: (хүлээн авагч буюу хүлээн авагч хүрээлэнгийн нэр хаяг, албан ёсны хүний нэр, холбогдох мэдээлэл\*) (цаашид “Хүлээн авагч гэх”)

1.3 Энэ Гэрээнд нэгдсэн талууд дараах тохиролцоонд хүрч байна:

## ЗҮЙЛ 2 – НЭР ТОМЪЕОНЫ ТАЙЛБАР

Энэхүү Гэрээнд ашиглаж байгаа нэр томъёонууд дараах холбогдох утгыг агуулна.

”Хязгаарлалтгүй хүртээмжтэй байх”: Хэрэв Бүтээгдэхүүнийг Олон Улсын Гэрээнд заасанчилан эрдэм шинжилгээ, судалгаа, селекцийн зориулалтаар бусдад ашиглуулахад ямар нэг хуулийн, гэрээний болон технологийн хязгаарлалт, саад байхгүй байвал түүнийг эрдэм шинжилгээ, судалгаа, селекцийн ажилд ямар нэг хязгаарлалтгүйгээр ашиглах боломжтой гэж үзнэ.

“Удирдах байгууллага”: Гэрээний Удирдах байгууллага.

“Ашиглах эрх болон үр ашгийг хуваарилах олон талт тогтолцоо”: Олон улсын гэрээний 10.2 дугаар зүйл заалтыг үндэслэн байгуулсан Ашиглах эрх болон үр ашгийг хуваарилах олон талт тогтолцоо.

“Судалгааны шатанд байгаа Хүнс Хөдөө Аж Ахуйн Ургамлын Генетик Нөөц”: гэдэг нь нэг материалаас гаргаж авсан өөр Материал бөгөөд шинж тэмдгийн хувьд эх материалаас өөр, арай арилжаанд ороогүй буюу түүнийг зохиогч нь цаашдаа өөр хүн, байгууллагад дараагийн шатны судалгаанд шилжүүлэх зорилготой байгаа. Судалгааны шатанд байгаа Хүнс Хөдөө Аж Ахуйн Ургамлын Генетик Нөөц нь Бүтээгдэхүүн болж арилжаанд ормогц түүнийг судлах хугацаа дуусгавар болно.



“Бүтээгдэхүүн” гэдэг нь ямар нэг генетик материал болон түүний генийн тодорхой хэсгийг өөртөө агуулсан, арилжаанд оруулахад бэлэн болсон Хүнс Хөдөө Аж Ахуйн Ургамлын Генетик Нөөц бөгөөд хүнс, тэжээл, боловсруулах үйлдвэрлэлд ашиглаж байгаа бүтээгдэхүүнээс ангид ойлголт.

“Борлуулалт”: Бүтээгдэхүүнийг Хүлээн авагч болон түүний салбарууд, гэрээт харилцагчид, лиценз эзэмшигчид, түрээслэгчид арилжаанд оруулсны үр дүнд бий болж байгаа орлого,

“Арилжаалах”: Бүтээгдэхүүнийг мөнгө олох зорилгоор нээлттэй зах зээлд борлуулах тухай ойлголт бөгөөд “арилжаалах” гэдэг нь харгалзах утгатай байна. Арилжаалах гэдэг ойлголтонд “Судалгааны шатанд байгаа Хүнс Хөдөө Аж Ахуйн Ургамлын Генетик Нөөц”-ийн ямар нэг хэлбэр хамаарахгүй.

### ЗҮЙЛ 3 – СТАНДАРТ МАТЕРИАЛ ДАМЖУУЛАХ ГЭРЭЭНД ХАМААРАХ ЗҮЙЛ

Хүнс Хөдөө Аж Ахуйн Ургамлын Генетик Нөөцийн Олон Улсын Гэрээний 1-р хавсралтанд заасан Хүнс Хөдөө Аж Ахуйн Ургамлын Генетик Нөөцийг (үүнээс хойш “Материал” гэж нэрлэх), Гэрээний 5b дүгээр Зүйл болон 1-р хавсралтанд заасан холбогдох мэдээллүүдийн хамт Нийлүүлэгчээс Хүлээн авагчид дамжуулж байгаа гэрээний нөхцлүүдийг хамруулан ойлгоно.

### ЗҮЙЛ 4 – ЕРӨНХИЙ ЗААЛТУУД

4.1 Энэхүү Гэрээ нь Ашиглах эрх болон үр ашгийг хуваарилах олон талт тогтолцооны нэгэн хэсэг бөгөөд ХХААУГН-ийн Олон Улсын Гэрээний зорилтууд, зүйл заалтуудад нийцүүлэн хэрэгжүүлнэ.

4.2 Хэлэлцээрт Нэгдэн Орсон Талуудын хамтарч баталсан хуульчилсан арга хэмжээ, аргачлалуудыг ялангуяа Хэлэлцээрийн 4,12.2 болон 12.5 дугаар заалтуудыг баталгаажуулж дагаж мөрдөх үүрэгтэйг хүлээн зөвшөөрсөн байна

4.3 Гэрээний Удирдах Байгууллагын болон Олон талт тогтолцооны нэрийн өмнөөс аливаа үйлдэл хийх эрх энэхүү Гэрээнээс үр дүн хүртэгч гуравдагч талд байна гэдэгтэй энэхүү Гэрээнд оролцогч талууд санал нэг байна.

4.4 Гуравдагч тал нь энэхүү Гэрээний 5e, 6.5c, 8.3 дугаар зүйлүүд болон Хавсралт 2 ба 3-р догол мөрөнд заасанчлан зөв тодорхой мэдээллийг шаардах эрхтэй байна.

4.5 Удирдах байгууллагаас сонгосон хуулийн этгээдэд олгосон дээрх эрх нь Нийлүүлэгч болон Хүлээн авагчийг энэхүү Гэрээний хүрээнд эрхээ эдлэхийг хязгаарлахгүй.

### ЗҮЙЛ 5 – НИЙЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Нийлүүлэгч нь Материалыг дамжуулахдаа Хэлэлцээрийн дараах заалтуудыг баримтална: Үүнд:

а) Ашиглах эрхийг ямар нэг төлбөргүйгээр, хэрэв төлбөртэй бол хамгийн бага зардлаар тооцож богино хугацаанд, хурдан харилцан тохиролцож олгоно.

б) Нийлүүлж байгаа хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн хамт түүний паспортийн бүртгэлийн мэдээлэл, түүнд хамааралтай мөрдөгдөж байгаа хууль дүрэм журам, нууцын зэрэглэлд хамаарахгүй бусад тайлбар мэдээллүүдийг бас нийлүүлнэ.

в) Судалгааны шатанд байгаа Хүнс Хөдөө Аж Ахуйн Ургамлын Генетик Нөөц, тухайлбал фермерүүдийн бүтээсэн сортуудыг ашиглах эрх нь бүтээлийг эзэмшигчийн саналаар шийдэгдэнэ.

д) Оюуны өмчийн болон бусад эрхээр хамгаалагдсан хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцүүд нь холбогдох олон улсын хэлэлцээр болон дотоодын хууль дүрмээр зохицуулагдана.

е) Нийлүүлэгч нь хэрэгжүүлсэн Материал дамжуулах гэрээний тухай мэдээллийг тодорхой цаг хугацаа тутамд Удирдах байгууллагад хүргүүлж Удирдах байгууллагаас гаргасан хуваарьт оруулна. Удирдах байгууллагаас энэхүү мэдээллийг гуравдахь талын ашиг хүртэгчдэд хүртээмжтэй байлгана.

## ЗҮЙЛ 6 - ХҮЛЭЭН АВАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

6.1 Зөвхөн хүнс, хөдөө аж ахуйн чиглэлийн судалгаа, селекцийн ажил, сургалтанд зориулж генетик нөөцийг хадгалж, ашиглах зориулалтаар ашиглах эрхийг олгох ба энэ нь химийн, эм, эмийн бүтээгдэхүүн болон бусад хүнс, тэжээлийн бус үйлдвэрлэлд хамаарахгүй.

6.2 Олон Талт Тогтолцооны хүрээнд хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөц, тэдгээрийн генетикийн материалын аль нэг хэсгийг хүлээн авсан тал нь материалыг ашиглах эрхийг хязгаарлах аливаа оюуны өмчийн болон бусад эрх авах нэхэмжлэл гаргахгүй.

6.3 Олон Талт Тогтолцооны хүрээнд авч хадгалсан хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг энэхүү Гэрээний нөхцлүүдээр Олон Талт Тогтолцооны хүрээнд цаашид бусад талууд хүлээн авах боломж олгоно.

6.4 Энэ Гэрээний хүрээнд Хүлээн авагчийн хүлээн авсан Материалыг дараагийн хүн эсвэл байгууллагад дамжуулах тохиолдолд (үүнээс хойш дараагийн хүлээн авагч гэж нэрлэх) дараагийн Хүлээн авагч нь доорх үүргийг хүлээнэ. Үүнд:

a) Стандарт материал дамжуулах гэрээний нөхцлийн дагуу шинээр материал дамжуулах гэрээ байгуулна,

b) Гэрээний 5е зүйлд заасны дагуу Удирдах байгууллагад мэдэгдэх,

Хүлээн авагч нь дээрх нөхцлүүдээс өөр нэмэлт үүргийг Дараагийн хүлээн авагчийн өмнө хүлээхгүй.

6.5 Хэрэв Хүлээн авагч нь Судалгааны шатанд байгаа Хүнс Хөдөө Аж Ахуйн Ургамлын Генетик Нөөцийг өөр хүнд дамжуулах болбол дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

a) Стандарт материал дамжуулах гэрээний нөхцлийн дагуу шинээр материал дамжуулах гэрээ байгуулна. Энэ тохиолдолд Стандарт материал дамжуулах гэрээний 5а заалт үйлчлэхгүй.

b) Бусдад дамжуулж байгаа Судалгааны шатанд байгаа хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөц нь Олон Талт Тогтолцооны хүрээнд хүлээн авсан Материалаас эхтэй болохыг Материал дамжуулах шинэ гэрээнд тусгах ялангуяа Олон Улсын Гэрээний 1-р хавсралттай тулгах,

c) Гэрээний 5е зүйлд заасны дагуу Удирдах байгууллагад мэдэгдэх,

d) Өөр нэмэлт үүргийг Дараагийн хүлээн авагчийн өмнө хүлээхгүй байх.

6.6 Энэ Гэрээний 6.5-р зүйлийн хүрээнд материал дамжуулах гэрээ байгуулах явцад тухайн материалтай холбоотой нэмэлт нөхцлүүд тухайлбал шаардлагатай тохиолдолд мөнгөн төлбөрийн тухай зэрэг нэмэлт оруулах талуудын эрхийг хязгаарлахгүй.

6.7 Хэрэв Хүлээн авагч тал нь Бүтээгдэхүүнийг тухайлбал энэ гэрээний 3-р зүйлд заасан хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөц буюу Материалыг арилжаанд оруулсан мөн бүтээгдэхүүн нь ямар нэг хязгаарлалтгүйгээр бусдад хүртээмжтэй биш байвал Хүлээн авагч тал бүтээгдэхүүний Орлогоос тодорхой хувийг Удирдах байгууллагаас тогтоосон хувь хэмжээгээр энэ Гэрээний Хавсралт-2 заасны дагуу төлнө.

6.8 Хэрэв Хүлээн авагч Бүтээгдэхүүнийг тухайлбал энэ гэрээний 3-р зүйлд заасан хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөц буюу Материалыг нь арилжаанд оруулсан мөн бүтээгдэхүүн нь ямар нэг хязгаарлалтгүйгээр бусдад хүртээмжтэй байвал Хүлээн авагч тал сайн дураар бүтээгдэхүүний Орлогоос тодорхой төлбөрийг Удирдах байгууллагаас тогтоосон хувь хэмжээгээр энэ Гэрээний Хавсралт-2 заасны дагуу төлнө.

6.9 Хүлээн авагч нь Олон Улсын Гэрээний баримт бичгийн 17-р зүйлд заасан мэдээллийн системээр дамжуулан хүлээн авсан Материалд хийсэн бүхий л судалгааны үр дүнгийн тухай нууц биш мэдээллийг Олон Талт Тогтолцоонд өгөх үүрэгтэй. Мөн Олон Улсын Гэрээний 13.2 -р зүйлд заасанчлан судалгааны мөнгөн бус үр ашгаас Олон Талт Тогтолцоонд хүртээхийг дэмжинэ. Материалыг ашиглаж бий болсон Бүтээгдэхүүний зохиогчийн эрхийн үйлчлэх хугацаа дуусгавар болсон тохиолдолд Хүлээн авагч нь энэ Бүтээгдэхүүний дээжийг Олон Талт Тогтолцооны цуглуулгад нэгтгэж цаашдын судалгаа, селекцийн ажилд ашиглах боломж олгоно.

6.10 Олон Талт Тогтолцоогоор дамжуулан авсан Материал, түүний тодорхой хэсгийг ашиглаж бий болсон Бүтээгдэхүүний зохиогчийн эрхийг авсан Хүлээн авагч тал нь зохиогчийн эрхийг гуравдагч талд шилжүүлэх тохиолдолд энэхүү Гэрээгээр хүлээсэн ашиг хуваах үүргийг мөн давхар шилжүүлэх шаардлагатай.

6.11 Хүлээн авагч нь гэрээний 6.7-р зүйлд заасанчлан 4 дүгээр Хавсралтын загварын дагуу төлбөрийн хувилбаруудаас сонгох боломжтой:

a) Хүлээн авагч нь төлбөрийн сонголтууд хүчин төгөлдөр байгаа нөхцөлд төлбөрийг бууруулсан хувилбараар хийнэ.

b) Төлбөрийн сонголтууд хүчин төгөлдөр байх хугацаа энэ Гэрээний 3-р Хавсралтын дагуу 10 жил тутамд шинэчлэгдэнэ.

c) Төлбөрийн хэмжээ нь Бүтээгдэхүүний борлуулалтын хэмжээнд үндэслэх бөгөөд Олон улсын гэрээний 1-р хавсралтын ургамлын жагсаалтад орсон ижил төрлийн ургамлын хүнс хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн хувьд төлбөр адилхан байна.

d) Тухайн Бүтээгдэхүүн хязгаарлалтгүйгээр бусдад хүртээмжтэй эсэхээс үл хамааран төлбөр бие даан хийгдэх болно.

e) Энэ төлбөрийн хувилбарт баримталж байгаа төлбөрийн хэмжээ, нөхцөл, бууруулсан хувь хэмжээ зэргийг энэхүү Гэрээний 3-р хавсралтад үзүүлэв,

f) Хүлээн авагч нь энэхүү Гэрээний 6.7-р зүйлд заасан төлбөрийн болон ургамлын материал дамжуулах өмнөх гэрээгээр үүссэн үүргээс чөлөөлөгдөнө,

g) Хэрэв Бүтээгдэхүүн нь хязгаарлалтгүйгээр хүртээмжтэй байж чадахгүй байгаа тохиолдолд хүчин төгөлдөр хугацаа дууссаны дараа Хүлээн авагч нь энэ Материалыг өөртөө агуулсан Бүтээгдэхүүн бүрт энэ заалт хүчин төгөлдөр хугацааны турш төлбөр төлнө. Төлбөрийн хэмжээг (a) заалтын дагуу тооцоолно.

h) Хүлээн авагч нь төлбөрийн ямар хэлбэрийг сонгосон тухайгаа Удирдах байгууллагад мэдэгдсэн байна. Хэрэв мэдэгдэл ирээгүй бол 6.7-р Зүйлд заасны дагуу төлбөрийн зохих хэлбэрийг оногдуулна.

## ЗҮЙЛ 7 – ХЭРЭГЛЭХ ХУУЛЬ ТОГТООМЖ

2004 оны Олон Улсын Худалдааны Гэрээний зарчим, ХХААУГНОУГ Гэрээний зорилтууд, холбогдох заалтууд, шаардлагатай тохиолдолд Удирдах байгууллагын шийдвэрүүдийг ашиглана.

## ЗҮЙЛ 8 – МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

8.1 Нийлүүлэгч, Хүлээн авагч эсвэл Олон Улсын Гэрээний Удирдах байгууллага, Олон Талт Тогтолцоог (Удирдах байгууллагаас томилсон хуулийн этгээд) төлөөлж байгаа этгээдүүд маргаан шийдвэрлэх асуудлыг санаачилж болно.

8.2 Олон Улсын Гэрээний Удирдах байгууллага ба Олон Талт Тогтолцоог (Удирдах байгууллагаас томилсон хуулийн этгээд) төлөөлж байгаа этгээд гуравдагч этгээдийн хувьд Нийлүүлэгч ба Хүлээн авагчийн эрх, үүрэгтэй холбоотой аливаа маргаан шийдвэрлэх асуудлыг санаачлах эрх эдэлнэ гэдэгтэй энэхүү Гэрээнд оролцогч талууд санал нэгтэй байна.

8.3 Гуравдагч талаас энэхүү Гэрээний агуулгаар Нийлүүлэгч ба Хүлээн авагч талуудаас тэдгээрийн эрх, үүрэгтэй холбоотой аливаа асуудлаар тодорхой мэдээлэл, баримт шаардах эрх эдэлнэ. Эдгээр мэдээлэл, баримтуудыг шаардах бүрд Нийлүүлэгч ба Хүлээн авагч талууд гаргаж өгөх шаардлагатай.

8.4 Энэхүү Гэрээнээс үүдэлтэй аливаа маргааныг дараах байдлаар шийдвэрлэнэ:

a) Маргааныг эвээр шийдвэрлэх. Талууд маргааныг хэлэлцээр хийж харилцан буулт хийж шийдвэрлэнэ.

b) Зуучлагчаар дамжуулж маргаан шийдвэрлэх. Хэрэв талууд хэлэлцээр хийж маргааныг шийдвэрлэх боломжгүй бол гуравдагч этгээдээр зуучлуулж болно.

c) Арбитрын шүүх: Хэрэв маргааныг хэлэлцээрийн болон зуучлалын замаар шийдвэрлэх боломжгүй бол талууд олон улсын Арбитрын хуулийн дагуу Арбитрын шүүхэд хандаж болно. Маргааныг хэлэлцээрийн журмаар шийдвэрлэж чадахгүй нөхцөлд Олон

улсын Худалдааны Танхимын Арбитрын Дүрэм Журмын дагуу нэг ба хэд хэдэн арбиторч оролцуулан шийдвэрлэнэ. Энэ зорилгоор Удирдах байгууллагаас арбиторчын жагсаалт гаргаж болох бөгөөд маргаанд оролцогч талууд өөрийн арбиторчыг энэ жагсаалтаас сонгох боломжтой төдийгүй талууд, тэдгээрийн томилсон арбиторууд харилцан тохирч даргалагч арбитор бусад арбиторыг томилох боломжтой. Эдгээр арбиторуудын ажлын үр дүн харилцан уялдах шаардлагатай болно.

## **ЗҮЙЛ 9 – НЭМЭЛТ ЗҮЙЛҮҮД**

### **Баталгаа**

9.1 Нийлүүлэгч талаас дамжуулж байгаа Материалын аюулгүй байдал, нэр болон түүнийг дагалдаж байгаа паспортын бүртгэл болон бусад мэдээлэл зөв, оновчтой эсэхэд баталгаа гаргахгүй. Мөн Материалын чанар, амьдралт, цэвэршилтэд (генетикийн төдийгүй механик) мөн баталгаа гаргахгүй. Материалын хорио цээрийн нөхцөл нь зөвхөн Хорио цээрийн гэрчилгээнд заагдсан хэм хэмжээгээр тодорхойлогдоно. Хүлээн авагч нь хүлээн авч байгаа улсын хорио цээр, биоаюулгүй байдлын болон генетикийн Материалыг импортлоход баримталдаг дүрэм журмыг дагаж мөрдөх үүрэг хүлээнэ.

Гэрээний үргэлжлэх хугацаа

9.2 Энэхүү гэрээ нь ХХААУГНОУГэрээ хүчин төгөлдөр байх бүхий л хугацаанд хүчинтэй үйлчилнэ.

## **ЗҮЙЛ 10 – ГАРЫН ҮСЭГ/ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ**

Нийлүүлэгч ба Хүлээн авагч талууд энэхүү Гэрээг гарын үсгээр баталгаажуулахыг шаардаагүй бол талууд ямар хэлбэрээр баталгаажуулж хүлээн авахыг сонгох боломжтой.

### **Хувилбар 1- Гарын үсэг**

Би (хууль ёсны албан тушаалтны бүтэн нэр) Хүнс Хөдөө Аж Ахуйн Ургамлын Генетик Нөөцийг хадгалах, тогтвортой ашиглах ажлыг дэмжих зорилгоор Нийлүүлэгчийн нэрийн өмнөөс энэ Гэрээг байгуулж, Гэрээний зүйл заалтуудыг дагаж мөрдөх манай байгууллагын үүрэг, хариуцлагыг бичгээр болон зарчмын хувьд хүлээн зөвшөөрч байгааг үүгээр баталж байна.

Гарын үсэг .....

Огноо .....

Нийлүүлэгчийн нэр .....

Би (хууль ёсны албан тушаалтны бүтэн нэр) Хүнс Хөдөө Аж Ахуйн Ургамлын Генетик Нөөцийг хадгалах, тогтвортой ашиглах ажлыг дэмжих зорилгоор Хүлээн авагчийн нэрийн өмнөөс энэ Гэрээг байгуулж, Гэрээний зүйл заалтуудыг дагаж мөрдөх манай байгууллагын үүрэг, хариуцлагыг бичгээр болон зарчмын хувьд хүлээн зөвшөөрч байгааг үүгээр баталж байна.

Гарын үсэг .....

Огноо .....

Хүлээн авагчийн нэр .....

### **Хувилбар 2 –Стандарт Материал Дамжуулах Багцалсан Гэрээ**

Энэхүү Гэрээний нөхцлийн дагуу Материалыг нийлүүлсэн байна. Материалыг Нийлүүлэгчийн зүгээс нийлүүлэх, түүнийг Хүлээн авагч тал хүлээн авч ашиглах бүх харилцааг Гэрээнд заасан нөхцлийг үндэслэн тогтооно.

### **Хувилбар 3 - Стандарт Материал Дамжуулах Электрон Гэрээ**

○ Би дээрх нөхцлийг зөвшөөрч байна.

**САНАЛ БОЛГОЖ БАЙГАА МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ**

Энэ Хавсралтад энэхүү Гэрээгээр зохицуулж болох Материалын жагсаалтыг, 5b Зүйлтэй хамааралтай холбогдох мэдээллийн хамт агуулсан байна.

Энэ мэдээллийг цахим хуудаснаас авч болно эсвэл доор тайлбарласан байдлаар авна.

Жагсаалтанд байгаа Материал бүрийг дараах мэдээлэл дагалдана: Үүнд: паспортын бүртгэлийн боломжтой бүх мэдээлэл, үйлчлэх хууль тогтоомжууд, нууцын зэрэглэлгүй бусад шаардлагатай мэдээллүүд.

**СМДГ-НИЙ ХАВСРАЛТ - 2**

**ЭНЭ ГЭРЭЭНИЙ 6.7-Р ЗҮЙЛД ЗААСАН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ, ТӨЛӨХ АРГА ХЭЛБЭР**

1. Хэрэв Хүлээн авагч болон түүний салбар, гэрээлэгчид, лиценз эзэмшигчид болон түрээслэгчид нь Бүтээгдэхүүнийг арилжаалсан бол түүнээс олсон Орлогын нэг аравны нэг хувьтай (1.1%) тэнцэх төлбөр эсвэл олон тооны бүтээгдэхүүний хувьд гучин (30%) хувь хүртэл төлбөр төлнө. Харин үүнээс өөр дараах нөхцлүүдэд төлбөрөөс чөлөөлөгдөнө. Үүнд Бүтээгдэхүүн ба Бүтээгдэхүүнүүд нь:

а) Энэ Гэрээний 2-р Зүйлд заасанчлан судалгаа, селекцийн ажилд зориулж ашиглахад бусдад ямар нэг Хязгаарлалтгүй хүртээмжтэй байгаа тохиолдолд,

б) Тухайн Бүтээгдэхүүн ба Бүтээгдэхүүнүүдийн орлогод оногдох төлбөрийг төлсөн өөр хүн, хуулийн этгээдээс дамжуулан авсан эсвэл худалдан авсан эсвэл дээрх (а) заалтаар төлбөрийн үүргээс чөлөөлөгдсөн бол,

с) Генетик материал биш харин бараа бүтээгдэхүүн хэлбэрээр борлогдсон тохиолдолд,

2. Хэрэв Бүтээгдэхүүн нь Олон Талт Тогтолцоонд 2 ба түүнээс дээш удаагийн материал дамжуулах гэрээгээр шилжсэн Генетик Материалаас гаралтай байвал дээрх 1-р заалтаар шаардаж байгаа төлбөрийг төлөх зөвхөн нэг удаагийн үүрэг хүлээнэ.

3. Хүлээн авагч нь календарийн хугацаагаар жил бүрийн 12 сарын 31 өдрөөс хойш жар (60) хоногийн дотор Удирдах байгууллагад жилийн тайлан хүргүүлж байх үүрэгтэй:

а) Жилийн 12 сарын турш 12 сарын 31 өдөр хүртэл Хүлээн авагч болон түүний салбар, гэрээлэгчид, лиценз эзэмшигчид болон түрээслэгчид Бүтээгдэхүүн, ба Бүтээгдэхүүнүүдийг арилжаалж олсон Орлогын хэмжээ,

б) Үүргийн дагуу төлсөн төлбөрийн хэмжээ,

с) Ашиг хуваарилах болон төлбөр төлөхөд хүргэсэн хязгаарлалтын нөхцлүүдийн тухай мэдээллүүдийг тайланд тусгана.

4. Жилийн тайлан өгөхөөс өмнө төлбөрийг барагдуулсан байна. Бүх төлбөрийг заасан валютын төрлөөр ХХААУГНОУГэрээний Удирдах байгууллагын тусгай дансанд төлсөн байна.

**СМДГ-НИЙ ХАВСРАЛТ 3**

**ЭНЭ ГЭРЭЭНИЙ 6.11 ЗҮЙЛД ЗААСАН ТӨЛБӨРИЙН БУСАД ХЭЛБЭР БА НӨХЦЛҮҮД**

1. Гэрээний 6.11-р Зүйлд заасан төлбөрийг бууруулсан хэмжээ нь ХХААУГНОУГэрээний 1-р Хавсралтад заасан ижил төрлийн Хүнс Хөдөө Аж Ахуйн Ургамлын Генетик Нөөцөд хамаарах бүтээгдэхүүнд тэг аравны таван хувь (0.5%) байна.

2. Энэхүү Гэрээний 2-р Хавсралтын 4-рт заасан банкны мэдээлэлд тулгуурлан төлбөрийг гүйцэтгэнэ.

3. Хүлээн авагч нь Судалгааны шатанд байгаа Хүнс Хөдөө Аж Ахуйн Ургамлын Генетик Нөөцийг дамжуулвал Дараагийн хүлээн авагч нь Хэлэлцээрийн 19.3f-р Зүйлд заасанчлан Удирдах байгууллагаас баталсан журмын дагуу энэхүү Хүнс Хөдөө Аж Ахуйн

Ургамлын Генетик Нөөцийг ашиглан гаргаж авсан Бүтээгдэхүүний Орлогоос тэг аравны таван хувийг (0.5%) тухайн Бүтээгдэхүүн нь ямар нэг хязгаарлалтгүйгээр бусдад хүртээмжтэй эсэхээс үл хамааран төлнө.

4. Энэхүү Гэрээнд гарын үсэг зурснаас хойш арав дахь жил дуусахаас ядаж 6 сарын өмнө мөн дараагийн тав дахь жил дуусахаас 6 сарын өмнө Хүлээн авагч нь энэ зүйл заалтыг цаашид ашиглахаас татгалзах, дуусгавар болгох шийдвэрээ Удирдах байгууллагад ирүүлж болно. Хэрэв Хүлээн авагч тал өөр бусад Стандарт материал дамжуулах гэрээ байгуулсан бол арван жилийн хугацааг эхний гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн энэ Зүйл заалтын дагуу тооцно.

5. Хэрэв Хүлээн авагч тал ирээдүйд ижил төрлийн ургамлын өөр Стандарт Материал Дамжуулах Гэрээнд орвол Хүлээн авагч тал нь нэг л гэрээний Зүйл заалтыг баримтлан бүтээгдэхүүнд ноогдох төлбөрийг төлөх бөгөөд давхардсан төлбөр хийхгүй.

СМДГ-НИЙ ХАВСРАЛТ 4

ЭНЭ ГЭРЭЭНИЙ 6.11-Р ЗҮЙЛИЙН ТӨЛБӨРИЙН БУСАД ХЭЛБЭРҮҮД БУЮУ ТАРИМАЛ ДЭЭР СУУРИЛСАН ТӨЛБӨРИЙН ХЭЛБЭР

Би (Хүлээн авагч ба Хүлээн авагчийн хууль ёсны албан тушаалтны бүтэн нэр) энэ Гэрээний 6.11-р Зүйлд заасан төлбөрийн нөхцлийг хүлээн авч байгааг үүгээр баталж байна.

Гарын үсэг .....

Огноо .....

## ОЛОН ТАЛТ ТОГТОЛЦОООНД ХАМРАГДСАН УРГАМЛЫН ЖАГСААЛТ

## Хүнсний таримал ургамал

Оноосон англи нэр	Монгол нэр	Төрөл	тайлбар
Breadfruit		<i>Artocarpus</i>	Зөвхөн Breadfruit.
Asparagus	Хэрээнүд	<i>Asparagus</i>	
Oat	Хошуу будаа	<i>Avena</i>	
Beet	Хүрэн манжин	<i>Beta</i>	
Brassica complex	Байцааны төрлүүд	<i>Brassica et al.</i>	Энэ төрөлд : <i>Brassica, Armoracia, Barbarea, Camelina, Crambe, Diplotaxis, Eruca, Isatis, Lepidium, Raphanobrassica, Raphanus, Rorippa, and Sinapis</i> багтдаг. Эдгээр нь Үүнд байцаа, гич, навчит ногоонууд, улаан ба цагаан лууван, манжин зэрэг тосны болон хүнсний ногоонууд таримал ургамлууд хамаарна. Харин <i>Lepidium meyenii</i> (маса) зүйлүүд багтаагүй.
Pigeon Pea	Нүдгүй вандуй	<i>Cajanus</i>	
Chickpea	Вандуухай	<i>Cicer</i>	
Citrus	Цитрус	<i>Citrus</i>	<i>Poncirus</i> болон <i>Fortunella</i> төрлүүдийг залгуурга ургамлаар оруулав.
Coconut	Наргил	<i>Cocos</i>	
Major aroids	Ароидууд	<i>Colocasia, Xanthosoma</i>	taro, cocoyam, dasheen and tannia зэрэг Aroid-уудыг багтсан.
Carrot	Шар лууван	<i>Daucus</i>	
Yams	-	<i>Dioscorea</i>	
Finger Millet	Хуруу Бог будаа	<i>Eleusine</i>	
Strawberry	Гүзээлзгэнэ	<i>Fragaria</i>	
Sunflower	Наранцэцэг	<i>Helianthus</i>	
Barley	Арвай	<i>Hordeum</i>	
Sweet Potato	Амтат төмс	<i>Ipomoea</i>	
Grass pea	Төмөрдээ	<i>Lathyrus</i>	
Lentil	Сэвэгзарам	<i>Lens</i>	
Apple	Алим	<i>Malus</i>	
Cassava	Сүүт өвс	<i>Manihot</i>	Зөвхөн <i>Manihot esculenta</i>
Banana / Plantain	Гадил	<i>Musa</i>	<i>Musa textilis</i> -аас бусад.

Rice	Цагаан будаа	<i>Oryza</i>	
Pearl Millet	Зовлог	<i>Pennisetum</i>	
Beans	Шоинууд	<i>Phaseolus</i>	<i>Phaseolus polyanthus</i> –аас бусад.
Pea	Вандуй	<i>Pisum</i>	
Rye	Хөх тариа	<i>Secale</i>	
Potato	Төмс	<i>Solanum</i>	Section tuberosa included, except <i>Solanum phureja</i> . <i>Solanum phureja</i> -аас бусад булцуутнууд багтсан.
Eggplant	Цэс	<i>Solanum</i>	<i>melongena</i> багтсан.
Sorghum	Шиш	<i>Sorghum</i>	
Triticale	Тритикал	<i>Triticosecale</i>	
Wheat	Буудай	<i>Triticum et al.</i>	<i>Agropyron</i> , <i>Elymus</i> , and <i>Secale</i> багтсан.
Faba Bean / Vetch	Ггийс	<i>Vicia</i>	
Cowpea et al.	Бурчиг	<i>Vigna</i>	
Maize	Эрдэнэшиш	<i>Zea</i>	<i>Zea perennis</i> , <i>Zea diploperennis</i> , and <i>Zea luxuriana</i> багтаагүй.

Тэжээлийн ургамлууд

Төрөл	Зүйл	Монгол нэр
LEGUME FORAGES		БУУРЦАГТ ТЭЖЭЭЛИЙН УРГАМЛУУД
<i>Astragalus</i>	<i>chinensis, cicer, arenarius</i>	Хунчир
<i>Canavalia</i>	<i>ensiformis</i>	Монгол нэршил байхгүй
<i>Coronilla</i>	<i>varia</i>	Монгол нэршил байхгүй
<i>Hedysarum</i>	<i>coronarium</i>	Шимэрс
<i>Lathyrus</i>	<i>cicera, ciliolatus, hirsutus, ochrus, odoratus, sativus</i>	Төмөрдээ
<i>Lespedeza</i>	<i>cuneata, striata, stipulacea</i>	Бутлаг хошоонгор
<i>Lotus</i>	<i>corniculatus, subbiflorus, uliginosus</i>	хошоонцор
<i>Lupinus</i>	<i>albus, angustifolius, luteus</i>	Шошлой
<i>Medicago</i>	<i>arborea, falcata, sativa, scutellata, rigidula, truncatula</i>	Царгас
<i>Melilotus</i>	<i>albus, officinalis</i>	Хошоон
<i>Onobrychis</i>	<i>viciifolia</i>	Хүцэнгэ



<i>Ornithopus</i>	<i>sativus</i>	Шувуун хөл
<i>Prosopis</i>	<i>affinis, alba, chilensis, nigra, pallida</i>	Монгол нэршил байхгүй
<i>Pueraria</i>	<i>phaseoloides</i>	Монгол нэршил байхгүй
<i>Trifolium</i>	<i>alexandrinum, alpestre, ambiguum, angustifolium, arvense, agrocicerum, hybridum, incarnatum, pratense, repens, resupinatum, rueppellianum, semipilosum, subterraneum, vesiculosum</i>	Хошоонгор
GRASS FORAGES		ӨВСЛӨГ ТЭЖЭЭЛИЙН УРГАМЛУУД
<i>Andropogon</i>	<i>gayanus</i>	Монгол нэршил байхгүй
<i>Agropyron</i>	<i>cristatum, desertorum</i>	Зурман сүүл ерхөг , цөлийн ерхөг
<i>Agrostis</i>	<i>stolonifera, tenuis</i>	Найлзуурт улаан толгой.
<i>Alopecurus</i>	<i>pratensis</i>	Нугын Үнэгэн сүүл
<i>Arrhenatherum</i>	<i>elatus</i>	Үрээн сүүл
<i>Dactylis</i>	<i>glomerata</i>	Арзага
<i>Festuca</i>	<i>arundinacea, gigantea, heterophylla, ovina, pratensis, rubra</i>	Хонин Ботууль, улаан ботууль
<i>Lolium</i>	<i>hybridum, multiflorum, perenne, rigidum, temulentum</i>	Монгол нэршил байхгүй
<i>Phalaris</i>	<i>aquatica, arundinacea</i>	Орхиолөвс
<i>Phleum</i>	<i>pratense</i>	Дурваалиг
<i>Poa</i>	<i>alpina, annua, pratensis</i>	Тагийн биелиг, ганц наст биелиг, нугын биелиг
<i>Tripsacum</i>	<i>laxum</i>	Монгол нэршил байхгүй
OTHER FORAGES		БУСАД ТЭЖЭЭЛИЙН УРГАМАЛ
<i>Atriplex</i>	<i>halimus, nummularia</i>	Гагудай
<i>Salsola</i>	<i>vermiculata</i>	Бударгана